



**ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛ**

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид 2016 оны 09-р сарын 13-ны өдөр хуралдаж дараах 11-н асуулыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:



1. Ажлын хэсэг байгуулах тогтоолд өөрчлөлт оруулах тухай
2. Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтцэд өөрчлөлт оруулах тухай
3. Эд хөрөнгийн харилцааг зохицуулах журамд өөрчлөлт оруулан батлах тухай
4. Орон нутгийн өмчийн түрээслэх журмыг өөрчлөлт оруулан батлах тухай
5. Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар, журамд өөрчлөлт оруулан батлах тухай
6. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулан батлах тухай
7. Орон нутгийн өмчийн 2016 оны тооллогын дүн, илэрсэн зөрчлийн талаар авах арга хэмжээний тухай
8. Орон нутгийн өмчийн тухай
9. Сумдын худалдан авах ажиллагааг үнэлэх журмыг өөрчлөн батлах тухай
10. Иргэний зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
11. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

**АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТЭНД ОРОЛЦЛОО.**



Увс аймгийн ерөнхий боловсролын сургуулиуд, цэцэрлэг, болон Монголын үйлдвэрчний эвлэлийн харьяа Увс аймаг дахь хөдөлмөрийн дээд сургуулийн 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээ ёслол төгөлдөр боллоо.

Аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат Монголын үйлдвэрчний эвлэлийн харьяа Увс аймаг дахь хөдөлмөрийн дээд сургууль, Цогцолбор II сургууль болон "Ирээдүй" II цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн нээлтэнд оролцож оюутан, сурагч, бяцхан багачуудад сурлагын өндөр амжилт хүссэн юм.

"Ирээдүй" II цэцэрлэгт энэ хичээлийн жилд 310-н бяцхан үрс сурч, хүмүүжихээр

бүртгүүлсэн ба үүнээс 80-н шинээр элсэн орж байгаа юм байна.

Монголын үйлдвэрчний эвлэлийн харьяа Увс аймаг дахь хөдөлмөрийн дээд сургуульд энэ хичээлийн жилд 60 гаруй оюутан шинээр элсэн суралцаж байна.



**БНМАУ-ЫН БААТАР, ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, МАРШАЛ Ю.ЦЭДЭНБАЛЫН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЖ ӨНГӨРЛӨӨ.**



БНМАУ-ын Баатар, Хөдөлмөрийн Баатар, Маршал Ю.Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан 2016 оны 09-р сарын 22-ны өдөр түүнд зориулсан эрдэм шинжилгээний хурлаар эхэлсэн юм. Ю.Цэдэнбал агсны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, Монгол улсын тусгаар

тогтнол, нийгэм, эдийн засаг, соёлын салбарт оруулсан хувь нэмэрийг тодруулан гаргах, энэ талаар ард иргэд хийгээд залууст үнэн зөв мэдээлэл өгөх зорилгыг агуулсан энэхүү хуралд УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ч.Хүрэлбаатар, Аймгийн Засаг дарга Д.Батсайхан, ШУ-ны доктор, профессор, зурхайч Л.Тэрбиш болон Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Бал даргын төрөл төрөгсөд, хуучны танил нөхөд төрсөн сумынх нь зон олон, ойг зохион байгуулах комиссынхон, ОХУ-ын төлөөлөгчдөөс гадна баги, эрдэмтэн, судлаачид илтгэл тавьж өргөнөөр оролцлоо. Хуралд илтгэл тавьсан хүмүүст аймгийн Засаг дарга Д.Батсайхан хүндэтгэл үзүүлж ойн бэлэг гардууллаа. Мөн Монгол Оросын хамтарсан хөгжмийн хамтлагийн хүүхдүүд хүрэлцэн ирсэн олонд ая дууны бэлэг барьлаа.



09-р сарын 23-ны өдөр ойн арга хэмжээ баярын жагсаал, цэцэг өргөх ёслол, хүндэтгэлийн хурал, хүлээн авалтаар үргэлжилсэн юм. Ойн арга хэмжээний нээлтэнд Төр нийгмийн зүтгэлтнүүд, урлаг спортын алдартнууд, ИТХ-ын төлөөлөгчид, Бал даргын төрөл төрөгсөд, анд нөхөд, ОХУ-ын зочид төлөөлөгчид, ахмад буурлууд, албан байгууллагууд, хүүхэд багачууд өргөнөөр оролцлоо.

Маршал Ю.Цэдэнбал даргын мэндэлсний 100 жилийн ойд оролцохоор зочид төлөөлөгчид Увс аймагт хүрэлцэн ирсээр байна. ОХУ-ын Тува улсын Засгийн газрын тэргүүний орлогч Бичелдей Каадыр-Оол Алексеевич, Тувагийн ЗГ-ын тэргүүнээр ажиллаж байсан Ширишин.Г.Ч, Тува улсын Соёлын сайд Тамдын.А.К тэргүүтэй зочид Увс аймгийн Засаг дарга Д.Батсайханы албан өрөөнд зочиллоо.

Ю.Цэдэнбал агсны Орос-Монгол хоёр улсын найрамдалт харилцаанд ямар их үүрэг гүйцэтгэсэн, түүхэн хүний мэндэлсний 100 жилийн ойн арга хэмжээг талархан хүлээн авч биечлэн оролцохоор хүрэлцэн ирснээ ярьж байлаа. Тэрээр Ю.Цэдэнбал даргын Тува улсад ажлын айлчлал хийж байсныг дурдаад сайн хөрийн харилцаа, сайхан найз нөхөд явснаа ч дурсан ярьцаалаа. Эдгээр хүндэт зочдыг Аймгийн Засаг дарга Д.Батсайхан, УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, Аймгийн Засаг даргын орлогч Ц.Батболд, Засаг даргын зөвлөх Т.Нямсамбуу, ТЗУХ-ийн дарга У.Ганзориг нар хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Тува улсын зочид төлөөлөгчид Маршал Ю.Цэдэнбалын музейг үзэж сонирхлоо.







УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Юмжаагийн Цэдэнбал агсны хүү Цэдэнбалын Зориг, ач охин Анастасия Зориговна Цэдэнбал болон бага дүү өдгөө 88 настай Ю.Жавзан гуай, “Цэдэнбал Академи”-ийн тэргүүн дэд ерөнхийлөгч Ц.Жамбалсүрэн, МУ-ын аварга С.Мөнхбат, МУ-ын арслан П.Бүрэнтөгс болон Ю.Цэдэнбал агсны төрөл төрөгсөд 100 жилийн ойд оролцохоор Увс аймагт хуралцан ирсэн юм.

Ю.Цэдэнбал агсны 100 жилийн ойн бас нэгэн гол арга хэмжээнүүдийн нэг нь 10-н сарын 24-ний өдөр түүний төрсөн газар босгосон гэрэлт хөшөөний нээлт байлаа. Нээлтэнд УИХ-ын гишүүд, Аймгийн удирдлагууд хол, ойрын зочид, төрөл төрөгсөд, ОХУ-ын зочид төлөөлөгчид оролцлоо. Аймгийн ХЖТ-ын уран бүтээлчид тоглолтоо өргөн барьж, Дэчинравжаалин хийдийн лам нар ном хурж, хүндэт зочид нээлтийн тууз хайчилснаар арга хэмжээ эхэллээ. Гэрэлт хөшөөний нэг талд “Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын Баатар, Хөдөлмөрийн баатар, БНМАУ-ын Маршал Ю.Цэдэнбал нь XV жарны гал луу жилийн намрын дунд улаагчин тахиа сарын 21-ний өдөр ЦАГААН БУРАА хэмээх энэ газар мэндэлжээ ” Мэндэлсний 100 жилийн дурсгалд зориулав. 2016.09.17 гэж бичсэн бол нөгөө талд нь Уйгаржин Монгол бичгээр “Чингисийн тулганд ассан гал унтрах ёсгүй Юмжаагийн Цэдэнбал” хэмээн суут хүмүүний хэсэн үгийг сийлжээ. Энд сонирхуулан дурдахад энэхүү хөшөөнөөс хэдхэн метрийн зайд Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Өлзийтийн Бадрахын төрсөн газар байгаа нь “Цагаан бураа” хэмээх энэ газрын хүч, энэргий хэмжээг илгээнэ.

### ОЛОН УЛСЫН АХМАДЫН БАЯРЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Ахмад настны баярыг тэмдэглэх шийдвэрийг НУБ-аас анх 1990 онд гаргасан бөгөөд Монгол Улс 1992 оноос тэмдэглэж ирсэн бөгөөд жил бүрийн аравдугаар сарын 1-ний өдөр ахмадууддаа зориулж, хүндэтгэлийн арга

хэмжээ зохион байгуулдаг билээ. Баярын хүрээнд өнөөдөр ахмадууд маань Маршал Ю.Цэдэнбалын хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлээ.

Аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат, Засаг даргын зөвлөх Т.Нямсамбуу, АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Амраа нар баяр хүргэж, Маршал Ю.Цэдэнбалын 100 жилийн ойн тэмдэг, аймгийн хүндэт тэмдэг, аймгийн ИТХ-ын хүндэт өргөмжлөл, Засаг даргын “Жуух бичиг”-ээр зарим ахмадуудыг шагнаж урамшууллаа.

Ахмад настуудынхаа үнэт сургаалийг нь цаг үргэлж дээдлэн байх нь үр хойч болсон бидний үүрэг билээ.



### УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГСДИЙН ДУРСГАЛЫГ ХҮНДЭТГЭХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Монгол улсын нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн дагуу улс



төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг 21 дахь удаагаа улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлээ. Энэ өдөр Монголын төр, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн олон мянган иргэдийнхээ дурсгалыг хүндэтгэж, хэлмэгдлийн хор уршигийг олон түмэнд ойлгуулж таниулах хамгийн гол нь түүхийн хар толбо болсон бусармаг үйлдэл давтагдахаас сэргийлэхэд чиглэгдсэн тодорхой ажил зохион байгуулж, хэлмэгдсэн хүмүүсийн үр хүүхэд, ач зээ нар т хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай.

Энэ удаагийн үйл ажиллагаанд Аймгийн ИТХ-ын дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын дарга Э.Насанбат, ЦАУЗБСК-ын нарийн бичгийн дарга Х.Даишэвэг, Улаангом сумын ЦАУЗБСК-ын дарга Б.Жавхлантөгс, нарийн бичгийн дарга Ж.Очирбат, Улаангом сумын Засаг дарга О.Ганхуяг болон хэлмэгдэгсдийн ар гэр, үр хүүхэд, ач зээ нар нь Улаан уулан дахь Хэлмэгдэгсдийн хөшөөнд цэцэг өргөлөө. Мөн Дэчинравжаалин хийдийн лам нар нь ном хурж, хэлмэгдэгсдийн ар гэрт хүндэтгэл үзүүлээ.

### ДАВСТ СУМ

Давст сумын ИТХ нь жил бүрийн 9-р сарын 10-ны өдөр буюу “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх талаар ажлын төлөвлөөсөө боловсруулан тодорхой арга хэмжээ зохиодог. Үүнд:

- Улс төрийн хэлмэгдүүлэлтийн тухай сэдвээр Дунд сургуулийн түүх нийгмийн багш Баянтөгстэй хамтран 5-9-р ангийн сурагчдын дунд хичээл зааж, хэлмэгдүүлэлтийн тухай мэдээ мэдээлэлийг өгөв.

- Увс аймгийн улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалд зориулан гаргасан “Цагаан ном”-ыг ашиглан нэгдсэн судалгаа хийсэн байдаг. Уг судалгаагаар Давст сумаас 54 хүн цагаатгагдсан байдаг юм. Эдгээр хүмүүсээс 9 хүний ар гэрийнхэнд цагаатгалын нөхөн олговор олгогдсон бөгөөд 8- нь Давст суманд амьдарч байсан ба одоогоор 3 хүн эсэн мэнд аж төрөн сууж байна.

Сүүлийн 8,9 жилийн турш “ Улс төрийн хэлмэгдэгсдийн өдөр”-ийг тэмдэглэх ажлыг хэвшүүлсэн бөгөөд Дунд сургуулийн 5-9-р ангийн сурагчдын дунд 9-р сарын 5-аас 9-р сарын 10-ыг хүртэлхи хугацаанд аян зарлаж, хэлмэгдүүлэлтийн талаар танин мэдэхүйн хичээл заалаа.

### Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг  
Ө.Бадрахын гудамж,  
ЗДТГ-ын байр 210 тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал